



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2022 оны 02 сарын 22 өдөр

Дугаар 7/18


Улаанбаатар хот

Арилжаанд оролцох эрх олгох тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, "Монголын хөрөнгийн бирж" төрийн өмчит хувьцаат компанийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.1, 8.10.11 дэх заалт, "Үнэт цаасны арилжаанд оролцох эрх олгох журам"-ын 2 дугаар зүйлийн 2.3.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн гишүүн "Райнос Инвестмент ҮЦК" ХХК-нд үнэт цаасны арилжаанд оролцох "FIX" эрх шинээр нэмж олгосугай.
2. Арилжаанд оролцох эрх авсан компанид Монгол улсын үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль тогтоомж, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, өндөр хариуцлага, ёс зүйтэй ажиллахыг үүрэг болгосугай.
3. Үнэт цаасны арилжаанд программд нэвтрэх нэр, нууц үг олгох ажлыг Үйл ажиллагааны газрын Арилжааны алба /Д.Алдармаа/-нд, тушаалын биелэлтэд Хяналт тавьж ажиллахыг Хяналт, зохицуулатын газрын Хяналт шинжилгээний алба /Д.Баттулга/-нд даатгасугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ


Х.АЛТАЙ

1522030028

00 682

“РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК” ХХК-ийн арилжаанд оролцох эрх олгох журмын шаардлага хангасан эсэх

Д/д	Журмын шаардлага	Хангасан эсэх
1	СЗХ-ноос “Үнэт цаасны зах зээлд үнэт цаасны зуучлалын чиглэлээр мэргэжлийн ажил, үйлчилгээ явуулах эрх”-ийн үнэмлэхийн хугацаа хүчинтэй байх:	Үнэмлэхийн дугаар: 210518/85 Хүчинтэй хугацаа: 2026-12-04
2	Эрх олгох ажилтан нь гишүүн ҮЦК-ийн захирал, брокер, дилерийн аль нэг албан тушаалд томилогдсон, 3 ба түүнээс дээш сарын хугацаанд үндсэн үйл ажиллагааг хариуцан ажиллаж дадлагажсан байх:	Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх байгууллагад 3 сараас дээш хугацаанд ажилласан туршлага хангасан
3	Сүүлийн 6 сарын дотор журмын 3.1, 3.3-д заасан арга хэмжээ авагдаагүй байх:	Авагдаагүй байна
4	Үйлчилгээний хөлс 195,000 төгрөг төлсөн баримт:	2021.02.18-ны өдөр Дансаар төлсөн
5	Нэвтрэх эрхийн хураамж 20,000 төгрөг төлсөн баримт	2021.02.18-ны өдөр Дансаар төлсөн
6	Утасны дугаар:	75100575 info@rhinosinvest.mn